



**МОНГОЛ УЛС**  
**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ**  
**ТОГТООЛ**

2020 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Тогтоол, журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.5, 6.3.5, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын “дөрөвдүгээр хавсралтаар,” гэсний дараа “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тавдугаар хавсралтаар, Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагаас төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг зургаадугаар хавсралтаар” гэж тус тус нэмсүгэй.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолын 1 дэх заалтын “тавдугаар” гэснийг “долоодугаар” гэж өөрчилсүгэй.

3. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 211 дүгээр тогтоолоор баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох, төвлөрүүлэх журам”-д хавсралтад заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН  
АРИЛЖАА ЭРХЛЭГЧЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
1.1	<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>		
1.2	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх этгээд	200,000 төгрөг	Жил бүр
1.3	Үнэт металл, үнэт чулууны эдлэлээр арилжаа эрхлэх этгээд	200,000 төгрөг	Жил бүр
1.4	Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх хуулийн этгээд	1,000,000 төгрөг	Жил бүр
1.5	Үнэт металл, үнэт чулууны эдлэлээр арилжаа эрхлэх хуулийн этгээд	1,000,000 төгрөг	Жил бүр
	<b>ХОЁР. Хуульд заасан бусад тусгай зөвшөөрөл</b>		
2.1	Салбар, төлөөлөгчийн газар нээх	100,000 төгрөг	Тухай бүр
	<b>ГУРАВ. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>		
2.3	Оноосон нэр өөрчлөх	100,000 төгрөг	Тухай бүр
2.4	Тусгай зөвшөөрлийг сэргээх	100,000 төгрөг	Тухай бүр
2.5	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000 төгрөг	Тухай бүр

**ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГААС  
ТӨВЛӨРҮҮЛЭХ ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

	Зохицуулалттай үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
	<b>НЭГ. Тусгай зөвшөөрөл</b>		
1.1	Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа	500,000.00 төгрөг	Жил бүр
	<b>ХОЁР. Тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад үйлчилгээ</b>		
2.1	Үл хөдлөх эд хөрөнгийн менежментийн үйлчилгээ	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.2	Үл хөдлөх эд хөрөнгийг худалдан авч, засварлан борлуулах үйлчилгээ	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.3	Улаанбаатар хотод салбар нээх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.4	Орон нутагт салбар нээх зөвшөөрөл	40,000.00 төгрөг	Тухай бүр
2.5	Оноосон нэр өөрчлөх зөвшөөрөл	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.6	Тусгай зөвшөөрөл сэргээх	100,000.00 төгрөг	Тухай бүр
2.7	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт солих, шинэчлэх, нөхөн олгох	100,000.00 төгрөг	Тухай бүр
	<b>ГУРАВ. Эрх олгохтой холбоотой үйлчилгээ</b>		
3.1	Брокерын эрхийн үнэмлэх авах, солих, шинэчлэх, нөхөн олгох	50,000.00 төгрөг	Тухай бүр
3.2	Агентын эрх эрхийн үнэмлэх авах, солих, шинэчлэх, нөхөн олгох	50,000.00 төгрөг	Тухай бүр

